

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ДАХЬ ХҮНИЙ НЭРЭЭС ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Х.Мэргэнбат (Ph.D)

Өвөр Монголын Үндэстний Их Сургууль

Монгол судлалын сургуулийн багш, дэд профессор

Түлхүүр үг. Эртний монгол, дүрслэг сэтгэхүй, баатарлаг үзэл, тотем сэтгэхүй

Товч агуулга. Монгол хүний нэрийн цаана үндэстний түүх соёлын тэмдэг тамга буюу шинж онцлог гүн хадгалагдаж буй. Монгол үндэстний эртний нийгмийн түүхийн “нэвтэрхий толь” хэмээгдсэн “Монголын Нууц Товчоон”-д илэрдэг маш олон хүний нэрээс эртний монголчуудын сэтгэлгээний дүрслэг сэтгэхүй давамгайл байсан, баатарлаг үзлийг эрхэмлэн дээдэлж байсан, тотем сэтгэхүйн им тамга илэрч байсан зэргийг мэдэж болно.

Элвүүлэлд “Монголын нууц товчоон”-д дурдагдсан хүний нэрнээс эртний монголчуудын сэтгэлгээний зарим онцлогийг авч үзнэ.

“Хүн гарвал нэртэй Галуу гарвал дуутай” гэдэг цэцэн үгнээс Монголчууд эртнээсээ “нэр”-ийг ихэд хүндэтгэн анхаардаг байсныг мэдэж болно. Энэ тухай А.Пунсаг гуай <<“Монголын нууц товчоон” дахь ёс заншлын судалгаа>> хэмээх бүтээлдээ “монгол хүний нэр нь монголчуудын улс төр, эдийн засаг, түүх соёл, ёс заншил, гоо сайхан, шүтлэг бишрэл, үг хэл зэрэг олон салбарыг хамрахын зэрэгцээ үндэс угсаатануудын хоорон дахь соёлын харилцааны байдлыг харуулан тусгадаг онцлогтой ажээ”¹ хэмээн оновчтой хэлжээ.

“Монголын Нууц Товчоон” (цаашид “Нууц товчоон” хэмээн товчлон өгүүлэх болно) бол өнөө үед олдсон монгол үндэстний хамгийн эртний сонгодог сурвалж бичгийн нэг мөн. Тэр нь эртний монголчуудын улс төр, аж ахуй, цэрэг засаг, нийгэм түүх, хэл, уран зохиол, гүн ухаан, шашин шүтлэг, эм эмнэлэг, соёл иргэншил зэрэг олон талын судалгаанд чухал эх сурвалж учраас дэлхийн монгол судлалын эрдэмтдийн анхаарлыг татаж, нэгэнтээ дэлхийн хэмжээний судалгааны сэдэв болсон билээ. Үүнийг 1988 онд Өвөр Монголын Багшийн Их Сургуульд зохион байгуулагдсан “Нууц Товчоон”-ы олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурал, мөн 1990 онд Монгол улсын Улаанбаатар хотноо болсон “Нууц товчоон”-ы 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын агуулга, хүрээнээс олж харж болно. Монголч эрдэмтэн Ш.Бира үзэхдээ “Нууц товчоон” бол “эртний монголчуудын амьдрал зүй, түүх, хэл соёл, хэв заншлын нэг ёсны нэвтэрхий толийн агуу бүтээл мөн”² хэмээн ихэд өндрөөр үнэлсэн нь “Нууц товчоон”-ы эрдэм шинжилгээний ач холбогдлыг бүхий л талаас нь илэрхийлсэн байна.

Нэг. “Нууц товчоон” дахь хүний нэрийн ерөнхий онцлог

Судалгаанаас үндэслэвэл “Нууц товчоон”-д нийт дөрвөн зуу гаруй хүний нэр гардаг бөгөөд зарим хүний нэрийн оновчтой утгыг тодорхойлж чадаагүй гэдэг. Гэсэн хэдий ч ерөнхийдөө доор дурдсан онцлогуудыг мэдэж болно.

1. Хүний цол буюу гарал, хоч, ажил төрөл зэрэгт нь дүйцүүлэн нэрлэдэг онцлогтой. “Хан” буюу “хаан” бол эртний монгол үндэстний овог аймгийн ахлагчийн ерөнхий дуудлага нэр

1. А.Пунсаг. “Монголын нууц товчоон” дахь ёс заншлын судалгаа. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2010, 9 дэх тал

2. Г.Мөнх. Монголын гүн ухааны түүх. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1995. 67 дахь тал

болно. “Хан” болон “хаан”-ны хоорондох нарийн ялгааг Арджав гуай “Шинэ цоолборлосон Нууц товчоон”³ хэмээх бүтээлдээ нэлээд нарийвчлан тайлбарласан юм. “Нууц товчоон” дахь “хан”, “хаан” хэмээх зэрэг цол буюу тухайн хүний байр байдлыг илэрхийлсэн дуудлага нэр бүхий хүний нэр цөөн бус бий. Жишээлбэл: Батачи хан, Хабул хаан, Хотала хаан, Хадаан далдур хан, Чагур хан, Тоорил хан, Буйраг хан, Инанчи хан, Таян хан, Хүчүлэг хан, Чурам хан гэх мэт.

“Чэрби” бол эртний монголчуудын бас нэгэн зүйлийн хэргэм, зэргийн нэрийдэл буюу цол мөн. “Нууц товчоон”-д “чэрби” хэмээх цол буюу дуудлага нэртэй хүн олон байдаг. Жишээлбэл: Доголху чэрби, Тоорил чэрби, Додай чэрби, Өэлэн чэрби, Сүйхэтү чэрби, Толун чэрби, Бучаран чэрби, Бала чэрби зэрэг юм.

“Бэхи” хэмээх үг “Нууц товчоон”-д хоёр төрлийн утгатай байдаг. Нэг нь овог аймгийн доторхи нэр хүндтэй настан, нөгөө нь хааны хатан буюу хааны гүнжийг хэлнэ⁴. “Нууц товчоон”-д “бэхи” хэмээх үг бүхий хүний нэрсийг дурдвал: Саца бэхи, Хачиун бэхи, Хучар бэхи, Тогтоа бэхи, Хутуха бэхи, Билгэ бэхи, Чаур бэхи, Ибага бэхи, Сорхагтани бэхи, Төгс бэхи, Хожин бэхи, Алага бэхи зэрэг болно.

“Баян” бол нэн эртний монгол үндэстний хүний нийгмийн гарлыг илэрхийлсэн цол юм. “Нууц товчоон”-д “баян” хэмээх цолтой хүний нэрс нь Торголжин баян, Шинчи баян, Наху баян гэх мэтээр буй.

Хэдийгээр “гоо” нь өнөө үед “үзэсгэлэн гоо, гоёмсог” гэсэн утгатай боловч “Нууц товчоон”-д илэрсэн хүний нэрэнд энэ нь тийм биш юм. Харин эмэгтэй хүний нийгмийн байр суурь, гарлыг илтгэсэн цол байсан нь илэрхий. Жишээлбэл: Монголжин гоо, Борогчин гоо, Алун гуа гэх мэт болно.

“Хүргэн” бол нэн эртний хүний биеийн гарлыг илтгэсэн нэг зүйлийн дуудлага нэр юм. “Нууц товчоон”-д “хүргэн” хэмээх дуудлага нэртэй хүн цөөн бус байдаг. Жишээлбэл: Буха хүргэн, Ашиг хүргэн, Хадай хүргэн, Чигү хүргэн, Буту хүргэн, Алчи хүргэн, Хори хүргэн, Олар хүргэн гэх мэт билээ.

“Мэргэн” бол эртний монголчуудын гарамгай харваачийг нэрлэсэн цол мөн. “Нууц товчоон”-д “мэргэн” цол дагуулсан хүний нэр нийт тав байдаг. Тэдгээр нь Хоричар мэргэн, Боржигидай мэргэн, Добу мэргэн, Хорилардай мэргэн, Баргудай мэргэн болно.

“Баатар” бол эртний монголын овог аймгийн дээд давхаргатныг нэрлэдэг цол мөн. “Нууц товчоон”-д “баатар” хэмээх цол бүхий хүний нэр нэлээд бий. Жишээлбэл: Хабичи баатар, Начин баатар, Бүлтэчи баатар, Бартан баатар, Есүхэй баатар, Сүбээдэй баатар, Аучу баатар, Жирхин баатар, Хадаг баатар, Чирхидэй баатар, Тахай баатар, Чулуун баатар, Хүрэн баатар, Хадахай баатар гэх мэт.

“Сэцэн”-ийг “Нууц товчоон”-д хүний нэг зүйлийн хүндэтгэлийн дуудлага маягаар нэртэй холбогдуулан хэрэглэж байжээ. Жишээлбэл: Тумбинай сэцэн, Дай сэцэн, Хуйлдар сэцэн, Соху сэцэн, Жамуха сэцэн гэх мэт.

“Бөх” бол хүч чадал ихтэй бөхийн цол болно. Бөх барилдах бол монгол үндэстэний уламжлалт эрийн гурван наадмын нэг мөн. Тухайн үед “бөх” нь эр зориг, хүч чадлын бэлгэдэл байжээ. “Нууц товчоон”-д “бөх” цолтой хүн гэвэл Чидүүл бөх, Бүри бөх, Чилгэр бөх гэх мэтээр байна.

2. Хүний бие төрх, зан чанар зэрэг ямар нэгэн онцлогоор нь нэрлэх онцлогтой. Гадаад биеийн төрх бол хүний хамгийн илэрхий онцлог байж, бусдын анхаарлыг амархан татдаг. “Нууц товчоон”-д иймэрхүү гадаад бие төрхийн онцлогоор нэрлэсэн хүний нэр цөөн бус байдаг мөртөө ихээхэн ойлгомжтой дүрсэлсэн байдаг. Жишээлбэл: Их нүдэн, Дува сохор, Хар

3. Энэ тухай: Арджав. “Шинэ цоолборлосон монголын нууц товчоон”. Хөх хот. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо., 2010. 14-21 дэх талд үзнэ үү.

4. Элдэндэй, Оюундалай, Асралт. “Монголын нууц товчоон”-ы үгсийн тайлбар. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1980. 147 дахь тал

Хадаан, Сорхон шар, Мэнгэт, Таргудай Хирилтуг, Их Чилэдү, Чилгэр бөх, Дайдухул сохор, Ботоху тарган, Өвөгчин гэх мэт.

Зан чанар бол мөнхүү хүний илэрхий онцлогуудын нэг юм. “Нууц товчоон”-д зан чанарын онцлогоор нэрлэсэн хүний нэр олон бий. Жишээлбэл: Уужим Борхул, Ноёгдой, Атаргидай, Заль Бух, Мөч Битүүн, Хөгсэү Сабруг, Хишилэг, Мэхт, Дөрбэй Догшин гэх мэт.

3. “Төмөр”, “чулуу” зэрэг бат бэх чанар бүхий бодистой холбоотой буюу эртний монголчуудын ан ав, нүүдлийн мал аж ахуйтай холбогдол бүхий догшин амьтан, араатан, жигүүртнээр нэрлэсэн хүний нэр цөөн бус бий. Жишээлбэл: Тэмүжин, Тэмүгэ, Тэмүүлэн, Дай Төмөр, Бух Төмөр, Тогоон Төмөр, Ашиг төмөр, Чулуун, Чулуун хайч, Хатаги, Бөртэ Чино, Гуа Марал, Хасар (Хасар гэдэг нь хэдэр догшин, бие бялдар томтой нохойг хэлнэ), Бүри (Бүри гэдэг нь түрэг үг, нохойг хэлнэ) бөх, Хори Бух, Зали Бух, Алахай ит (ит гэдэг нь түрэг үг, нохойг хэлнэ), Начин баатар, Байшинхор догшин, Борулдай гэх мэт.

4. Харь үг зээлдсэн болон тэдгээр нь монгол үгтэй нийлэн бүрэлдсэн хүний нэр мөн цөөнгүй бий. Жишээлбэл: Түрэг хэл+монгол хэлнээс бүрэлдсэн “Алун гуа”, “Бүри бөх”, хятад хэл+монгол хэлнээс бүрэлдсэн “Сали Хачагу”, Сэнгүм Билгэ, монгол+төвд хэлнээс бүрэлдсэн “Их Чэрэн”, манж+монгол хэлнээс бүрэлдсэн “Дува сохор”, хятад+монгол хэлнээс бүрэлдсэн “Таян хан” гэх мэт болно.

Эдгээр хүний нэр нь эртний монгол үндэстэн бусад харь үндэстэнтэй харилцаа, холбоотой байсан ба харь үндэстний соёлын нөлөөг ямар нэг хэмжээгээр авсан түүхэн байдлыг харуулсан боловч эртний монголчуудын сэтгэлгээнд тийм ч чухал онцлог нөлөөгүй учир энэхүү өгүүлэлд нарийн тоочихгүй.

Хоёр. “Нууц товчоо”-н дахь хүний нэрээр дамжин илэрхийлсэн эртний монголчуудын сэтгэлгээний онцлог

Адил бус аж ахуй, нийгэм, түүхийн нөхцөлд өөр өөр үндэстэн угсаатны өвөрмөц онцлог бүхий соёл бий болж бүрэлддэг. Түүнчлэн өөр өөр соёлын орчин дахь хүмүүсийн үзэл, ухамсар, танин мэдэхүй, сэтгэлгээний онцлог харилцан адилгүй байдаг. Монгол үндэстэний урт удаан хугацааны түүхэн явцад монголын төвлөрөн суурьшсан тал нутагт ан ав, нүүдлийн мал аж ахуйн хэлбэрт түшиглэн өвөрмөц онцлог бүхий нүүдлийн мал аж ахуйн соёлыг бүрэлдүүлсэн бөгөөд түүнд тулгуурласан монгол үндэстэний танин мэдэхүйн сэтгэхүй ч бусад үндэстнээс ялгагдах өвөрмөц онцлогтой байдаг. Логик, философи, соёл иргэншлийн үүднээс өөр өөр үндэстний сэтгэлгээний арга хэлбэр, хэв шинжийг судлах нь туйлын шинэ сонин судалгааны сэдэв болох юм.

“Нууц товчоон” дахь хүний нэрнээс эртний монголчуудын хэрэг явдал, бодосыг танин мэдэх, танин мэдсэнээ нотлох зэрэг сэтгэлгээний талын доорхи хэдэн онцлогийг дурдаж болно.

1. Дүрслэг сэтгэхүй давамгай байрыг эзэлж байжээ.

Дүрслэг сэтгэхүйн тухай судалгааны өөр өөр төрөлд эл талаар өөр өөрийн гэсэн өвөрмөц тайлбарыг дэвшүүлдэг билээ. Хятад барын “Логикийн ухааны том толь бичиг”-т “Дүрслэг сэтгэхүй бол сэрэхүйн төсөөлөлд түшиглэн ургуулан бодох, дүрслэн бодох, хайр сэтгэлтэй уусан нэгдсэн сэтгэхүйн хөдөлгөөн мөн” гэсэн бол Зан Бөх гуай харин сурахуй хийгээд заахуйн үүднээс бол “Дүрслэг сэтгэхүй гэдэг нь нэгэнт байх илрэмжид түшиглэн явагддаг сэтгэхүйг хэлнэ” гэжээ. Эрдэнэтогтох нар танин мэдэхүйн онолын үүднээс “Дүрслэг сэтгэхүй бол шууд ажиглалтын зураг дүрс буюу суугдац сэтгэхүйн хөгжлийн хамгийн дээд хэлбэр болох буюу сэрлийн шууд ажиглалтын сэтгэхүйн хэлхээс системийн хөгжлийн дээд шат мөн. Тэр нь хүн

5. Пэн И Лиань, Ма Чин Рон. Логикийн ухааны том толь бичиг”. /хятад бар/. Шанхай: Шанхай Толь бичгийн хэвлэлийн хороо, 2004. 724 дэх тал

6. Зан Бөх. Залуу багачуудын сурахуй хийгээд заахын сэтгэл зүй. Шиньжиан. Люнинггийн үндэстэний хэвлэлийн хороо. 2009. 99 дэх тал

төрөлхтний танин мэдэхүйн сэтгэхүйн түүхэнд онолын сэтгэхүй буюу хийсвэр сэтгэхүй бий болохоос өмнө тухайн үндэстнээс ертөнцийг танин мэдэж, үнэн ёсч (бодит-Х.М) чанар бүхий үзэл санааг тоочин өгүүлэх хамгийн үндсэн, хамгийн түгээмэл, хамгийн дээд сэтгэхүйн илтгэх арга хэлбэр болсон байдаг” гэж өгүүлсэн билээ. Улмаар тэд “Монголчуудын онолын болон логик сэтгэхүй хөгжихөөс өмнө дүрслэг сэтгэхүй зонхилох байрыг эзэлж байсны хувьд монгол соёлд ихээхэн нөлөөлсөн байдаг”⁷ гэсэн нь эртний монголчуудын сэтгэлгээний хөгжлийн онцлогтой нийцэх юм.

Дүрслэг сэтгэхүй бол хүний оюунлиг танин мэдэхүйн хөдөлгөөн төдий биш, харин хийсвэр сэтгэхүйтэй адилхан нийтлэг чанар бүхий хүн төрөлхтний үндсэн сэтгэхүйн хэлбэрийн нэг төрөл болох юм. Ялангуяа хүн төрөлхтний нийгмийн анхны үед дүрслэг сэтгэхүй нь хүмүүсийн байгаль ертөнцийг таних, үзэл санаагаа тоочин өгүүлэх гол хэлбэр болж байжээ. “Нууц товчоон”-д гардаг хүний нэрийн ерөнхий онцлогоос эртний монголчуудын танин мэдэхүй, сэтгэхүйн хүрээнд дүрслэг сэтгэхүй давамгайл байрыг эзэлж байсан онцлогийг олж харна.

Мэдээж хэрэг хэргэм цол, биенийн гарал (жич биенийн төрх), зан чанар зэрэг бол хүний хамгийн илэрхий онцлог болно. Эртний монголчууд хүнийг танин нэрлэхдээ энэхүү илэрхий онцлогууд дээр төвлөрч, эдгээр онцлогоор нь заан нэр өгч байжээ.

Гэхдээ эдгээр цол буюу биенийн гарал, хоч нэр, ажил төрөл зэрэг нь тус хүний нэртэй уялдан нэгдэж, бусдаас ялгагдах чухал шинж онцлог болж илэрдэг. Жишээлбэл: “Хавт Хасар”-ын “хавт” гэдэг нь хүч чадал, ид хавтай гэх цол буюу өргөсөн нэр мөн.

Уул нэр “Хасар” гэдэгтэй нийлэн “Хавт Хасар” гэх туйлын дүрслэг ойлгомжтой хүний нэр болжээ. Бас жишээлбэл “Их Нүдэн” хэмээх нэрийг сонсох төдий том нүдтэй хүн мэтээр бидэнд төсөөлөгдөж, “Бух төмөр” хэмээх нэрийг сонсох бүр бух мэт хүдэр биерхэг, төмөр мэт бат чийрэг хүч, чадалтай монгол эрчүүд төсөөлөгддөг юм. Үүнээс гадна Чилгэр бөх, Чарха өвгөн, Хуагчин эмгэн, Сорхан шар гэх мэтийн ажил төрөл буюу ямар нэгэн онцлогоор нь нэрийдсэн хоч нэр нь эртний монголчуудын дүрслэг сэтгэхүй давамгайл байсныг гүйцэд харуулна. Эрдэмтэн профессор Х.Мөнх “Нууц товчоон” доторхи гүн ухааны үзэл санаа нь ерөнхийдөө шууд ажиглалтын чанартай, онолын сэтгэхүйн ул мөр байсан ч сэрэлийн дүрслэг сэтгэхүйн хүлээснээс бүрмөсөн ангижирч чадаагүй байсан”⁸ гэж дүгнэсэн нь бидний харьцуулсантай нийцэж байна.

2. Хүч, чадал, баатар зоригийг шүтэн бишрэх, баатарлаг үзлийг эрхэмлэн дээдэлж байжээ. Эртний монголчууд аль эрт ой шугуйд ан авд түшиглэн амьдарч байснаа аажмаар тал нутагт шилжин нүүдлийн мал аж ахуй түшиглэн амьдрах болсон хэмээх үзлийг олон эрдэмтэн зөвшөөрсөнөөс гадна “Нууц товчоон”-ы тэмдэглэлээс ч эл талаархи эш баримтыг олж болно. Тухайлбал “мэргэн” цол бүхий хүний нэр нь бүр “Нууц товчоон”-ы өмнөх 8 дугаар хэсэгт гардгаас Арджав гуай үзэхдээ: “Чингис хааны өвөг дээдсийн үед бараг ой шугуйд ан агнах хэлбэрээр амьдарч байсан бололтой. Иймээс “мэргэн” хэмээх цолтой хүн олон байжээ”¹⁰ гэсэн гаргалгаа хийж, улмаар “баатар” цол бүхий хүний нэр олширсноос үзвэл “Эртний монголчууд ой шугуйгаас аажмаар тал нутагт шилжин нутаглаж, нүүдлийн мал аж ахуйд түшиглэн амьдрах болсоноос эр чадалтай, эрэмгий баатарлаг хүмүүсийг “баатар” хэмээн цоллох болжээ”¹¹ хэмээн дүгнэсэн байна.

“Нууц товчоон”-д “мэргэн”, “баатар”, “сэцэн”, “билиг”, “бөх” зэрэг цол бүхий эрэлхэг,

7. Д.Эрдэнэтогтох, Мандах. Монгол үндэстний уламжлалт дүрслэг сэтгэхүй. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2001. 52 дахь тал

8. Мөн тэнд. 149-150 дахь тал

9. Г.Мөнх. Монголын гүн ухааны түүх. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1995. 72 дахь тал

10. Энэ тухай: Арджав. “Шинэ цоолборлосон монголын нууц товчоо”. Хөх хот. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо. 2010. 14-21 дэх талд үзнэ үү.

11. Мөн тэнд үзнэ үү.

баатарлаг хүч чадал ихтэй, ой ухаан сэцэн байхыг өргөмжилсөн хүний нэр олон байхаас гадна Тэмүжин, Бух төмөр, Чулуун, Чулуун хайч, Хатаги гэх мэтийн төмөр, чулуу, зэрэг баг бөх чанар бүхий бодостой холбоотой хүний нэр байх буюу эсвэл Бөртэ чоно, Гуа марал, Хасар, Бүри бөх, Алахай ит, Начин баатар гэх мэт дотшин араатан амьтан, жигүүртнээр нэрлэсэн хүний нэр цөөн бус илэрдэг. Энэ бүхнээс үзэхэд эртний монголчууд хүч чадал, баатар зоригийг шүтэн биширдэг баатарлаг үзлийг эрхэмлэн дээдэлж байжээ хэмээн ойлгож болно. Энэ нь монголчуудын урт удаан хугацааны амьдрал, тэмцэл, түүх, нийгмийн улиран хувьсах явцад монгол үндэстний өвөрмөц онцлог бүхий “хиан зориг санаа” болон бүрэлдсэн бөгөөд энэхүү зориг санаа нь бум, сая монгол үрсэд үе үе нөлөөлөн зоригжуулж, өөр өөр орчин, түүхэн ахуй, ажил үйлсэд ул мөрөө үлдээсээр иржээ.

Эртний монголчуудын ниймэрхүү хүч чадал, баатар зоригийг шүтэн бишрэх баатарлаг үзлийг эрхэмлэн дээдэлдэг сэтгэлгээний онцлог нь тэдний амьдран оршиж байсан хатуу бэрх байгаль орчин, үйлдвэрлэлийн хөгжил харьцангуй хоцрогдмол байсан цаг эрин ба адил бус овог аймаг, угсаа, бүлэгтний хоорондох удаан хугацааны өрсөлдөөн тэмцэлдээн түүх, нийгмийн ахуй нөхцөлтэй нягт холбоотой нь дамжиггүй.

3. Тотем сэтгэхүйн им тамга илэрч байжээ. Тотем шүтлэг бол хүн төрлөхтний нийгмийн үүслийн эхэн үеийн түгээмэл үзэгдэл мөн. Тотем шүтлэгийн жам ёс буюу онцлогийн тухай Р.Фрейр,¹² Зигмунд Фрейд,¹³ Х.Намжил¹⁴ зэрэг эрдэмтэн судлаачид өөр өөрөөр тайлбарласан байдаг ба Тү.Өлзий¹⁵ “тотем” хэмээх үгийг “этүгэн”, “удам” зэрэг үгтэй холбон шинжилсэнийг сонирхууштай.

Эрдэмтдийн олон талын судалгаа монгол үндэстэн эрт дээр үедээ тотем шүтлэгтэй байсан мэдээ сэлтийг илэрхийлсэн байдаг. Гэвч “Нууц товчоон”-оор дамжин илэрсэн нь бол зөвхөн тотем шүтлэгийн үлдвэр буюу им тамга төдий юм. Энэ нь дээр өгүүлсэн эрдэмтдийн дурдсан тотем шүтлэгийн жам ёс буюу онцлогоос ихээхэн ялгаатай юм. Бид “Балар эртний хүн ардын тотем шүтлэгийн үзэл, ойлголтоор ертөнцийг танин мэдэх сэтгэхүйн онцлогийг тотем сэтгэхүй гэж томъёолъё”¹⁶. Овог угсаа болон тэдний гишүүдийн тотем амьтны нэрээр нэрлэгдэх нь тотем сэтгэхүйн илрэх чухал нэг хэлбэр мөн. Эртний монголчуудын тотем амьтанд “чоно”, “буга” гэх мэт амьтад байдаг гэх үзлийг нийтээр зөвшөөрсөн хандлага ажиглагддаг. “Нууц товчоон”-ы хуудас эхэлмэгц “Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Гуа марал ажээ”¹⁷ хэмээн тэмдэглэснийг эрдэмтэд андуурхааргүй. Үүнд: “Бөртө чоно”, “Гуа марал” нь чухам түүхэн бодит хүн үү эсхүл язгуур монголын тотем шүтээний оногдохуун уу? эсхүл үнэхээр чоно ба буга уу гэдэг асуудлаарх эрдэмтэдийн санал хараахан нэгдээгүй ч өмнөх хоёр үзлийг баримтлагчид олонхийг эзэлсээр иржээ. Үүнээс гадна “Нууц товчоон”-д Хавт Хасар, Архай Хасар, Бүри бөх, Алахай ит, зэрэг “нохой”-гоор нэрлэсэн хүний нэр харагддаг. “Дарвины судалгааны үр дүнгээс үзвэл нохой нь өөр өөр цаг үед дэлхийн өөр өөр газар орны хүмүүс чоныг номхотгон тэжээсний үр дүн мөн. ...Зоу Бу Хью соёлын бууриас нохойн яс илрүүлсэн нь одоогоос 7000 жилийн өмнө Дундад улсын умардын үндэстний өвөг дээдэс нэгэнт чоныг номхотгон нохой болгон тэжээснийг харуулж, Сиян Зиян Дияаны дээд давхаргын соёл нь урьдах хүмүүсийн уламжлалыг залгамжилж, нохойг ан авд буюу хот хүрээг сахихад ашиглан аажмаар нохойг шүтэх, хүний оршуулгад нохойг дагалдуулан оршуулах хэвшил бий болсоныг харуулсан байна”¹⁸. Иймээс “Нууц товчоон”-д илэрсэн чоно буюу нохой,

12. Р.Фрейр. Баларлиг сэтгэхүй. Бээжин: Шан Эү хэвлэлийн хороо, 1986

13. Зигмунд Фрейд. Тотем ба цээр. Бээжин: Дундад улсын ардын урлагийн хэвлэлийн хороо, 1986

14. Энэ тухай Г.Намжил. Чоно тотем-алтай араатан угсаатны дамог үлгэрийн сурвалж, судлал. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо. 2009-ийг үзнэ үү.

15. Тү.Өлзий. Эртний монголчуудын соёл сэтгэхүй. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, 1997

16. Х.Мэргэнбат. Эртний монгол үндэстний логик үзэл санааны судлал-“Монголын нууц товчоон”-оор эшлэх нь. Докторын диссертаци. Тяньжин. Нэн Хэй Их Сургууль, 2012

17. Баярын галигласан “Монголын нууц товчоо” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1980. 1 дэх тал

18. Энэ тухай Г.Намжил. Чоно тотем-алтай араатан угсаатны дамог үлгэрийн сурвалж, судлал. Бээжин:

бугаар нэрлэсэн хүний нэр нь монголчуудын язгуур эртний тотем шүтлэгийн үлдэж ирсэн нөлөө буюу тотем сэтгэхүйн им тамга гэж ойлгохгүй байхын аргагүй.

Гэвч эдгээр хүний нэрэнд илэрсэн тотем сэтгэхүйн им тамгаар “Нууц товчоон”-д тусгагдсан цаг үеийн монголчууд тотем шүтлэгтэй байсан гэх дүгнэлт хийх нь зохисгүй юм. Учир нь энэ үеийн монголчуудын сэтгэхүй Р.Фрейд, З.Фрейд нарын ярьдаг баларлиг сэтгэхүйтэй харьцуулбал нэлээд хөгжсөн, боловсронгуй, боловсон хэмжээнд хүрсэн байдаг. Энэ тухай профессор Г.Мөнх гүн ухааны түүхийн үүднээс “Нууц товчоон”-г системжүүлэн судалж, “Нууц товчоон”-д гүн ухааны энэхүү хоёр шинж (хүн төрлөхтний танин мэдэхүйн түүхийн хураангуйлал ба тогтсон ангийн ертөнцийг үзэх үзлийн системжсэн онолжсон сургаал-эшлэгчээс) нь бүрэн тусгалаа олсон болохоор түүнийг монголын гүн ухааны түүхийн агуулга шинжийг хадгалсан сонгодог бичгийн зохиол мөн”¹⁹ хэмээн үнэлсэн байна. “Нууц товчоон”-оор дамжин илэрсэн эртний монголчуудын логик сэтгэхүйн шинж онцлогийг бусад өгүүллээр тусгай өгүүлэх учир энд тодорхой тоочсонгүйг тодруулах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Арджав. “Шинэ цоолборлосон монголын нууц товчоон”. Хөх хот. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо., 2010

Зан Бөх. Залуу багачуулын сурахуй хийгээд заахын сэтгэц зүй. Шиньжиан. Люнингийн үндэстний хэвлэлийн хороо. 2009

“Монголын нууц товчоо”. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1980

Г.Мөнх. Монголын гүн ухааны түүх. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1995

Х.Мэргэнбат. Эртний монгол үндэстний логик үзэл санааны судлал-“Монголын нууц товчоон”-оор эшлэх нь. Докторын диссертаци. Тяньжин. Нэн Хэй Их Сургууль, 2012

Г.Намжил. Чоно тотем-алтай араатан угсаатны домог үлгэрийн сурвалж, судлал. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо. 2009

Тү.Өлзий. Эртний монголчуудын соёл сэтгэхүй. Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, 1997

А.Пунсаг. “Монголын нууц товчоон” дахь ёс заншлын судалгаа. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2010

Пэн И Лиань, Ма Чин Рон. Логикийн ухааны том толь бичиг”. /хятад бар/. Шанхай: Шанхай Толь бичгийн хэвлэлийн хороо, 2004

Элдэндэй, Оюундалай, Асралт. “Монголын нууц товчоон”-ы үгсийн тайлбар. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1980

Д.Эрдэнэтогтох, Мандах. Монгол үндэстний уламжлалт дүрслэг сэтгэхүй. Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2001

Зигмунд Фрейд. Тотем ба цээр. Бээжин: Дундад улсын ардын урлагийн хэвлэлийн хороо, 1986

Р.Фрейд. Баларлиг сэтгэхүй. Бээжин: Шан Эү хэвлэлийн хороо, 1986